



МОНГОЛ УЛСЫН
БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 04 сарын 27 өдөр

Дугаар А/107

Улаанбаатар хот

Хөтөлбөрийг хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө
батлах тухай

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалт, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2017 оны 03-03 дугаар зөвлөмж, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 2017 оны 98 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Агаар, орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хавсралт ёсоор баталсугай.

2. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг салбар дундын уялдаатайгаар зохион байгуулж, гүйцэтгэлд нь хяналт тавьж, үр дүнг тогтоосон хугацаанд тайлагнаж ажиллахыг "Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо"-ны нарийн бичгийн дарга /Г.Нямдаваа/-д даалгасугай.

3. Төлөвлөгөөнд заасан арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулж, шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөв, гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулан төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд шийдвэрлэх замаар санхүүжүүлэн хэрэгжүүлж, үр дүнг тайлагнаж ажиллахыг бүх сайд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт зөвлөсүгэй.

САЙД  Д.ОЮУНХОРОЛ





Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017 оны 04-р сарын 27-ны өдрийн А/107 дугаар тушаалын хавсралт

АГААР, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Зорилго		Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангасан хот, суурин газрыг төлөвлөж, дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийн нэмэгдүүлэн бохирдлын эх үүсвэрийг багасгаж, хүн амд амьдрах орчны зөв дадлыг төлөвшүүлэх замаар агаар, орчны бохирдлыг бууруулж эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх		
Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр байгальд ээлтэй инженерийн дэд бүтцийн байгууламжийн чанар, хүртээмжийг сайжруулж, агаар, орчны бохирдуулагч эх үүсвэрийг багасган дулааны станц, дулааны цахилгаан станцаас бусад хэрэглээнд түүхий нүүрсийг хязгаарлаж, агаар, орчны бохирдлыг 80 хувиар бууруулна.		Хэрэгжилтийг хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжих хугацаа
Үр нөлөө (үр нөлөөний шалгуур үзүүлэлт)	Бүтээгдэхүүн	Шалгуур үзүүлэлт		
№	Үйл ажиллагаа			
Зорилт 1. Хот төлөвлөлт, байгуулалт, дэд бүтцийг хөгжүүлэх оновчтой бодлого хэрэгжүүлж, орон нутгийг хөгжүүлэх замаар төвлөрлийг сааруулан хот, суурин газрын агаар, орчны чанарыг сайжруулах				
Үйл ажиллагааны чиглэл 1. Хүн амын суурьшлын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, бүс нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх замаар нийслэлийн хүн амын төвлөрлийг зогсоох				
1.1.1	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл болон төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх	Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төсөл боловсруулж УИХ-аар батлуулсан байна. Түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, холбогдох байгууллагаар батлуулсан байна.	Холбогдох яам, агентлаг, АНЗД 2017-2019
			15 аймгийн хэмжээнд ерөнхий төслийг боловсруулсан байна.	Холбогдох яам, агентлаг, АНЗД 2018-2021